| 28 | ХОВО     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 48,40166 | 16,5596499 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 29 | ХОВО     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 48,40166 | 16,5728998 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 30 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 48,40166 | 16,5596499 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 31 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 53,54663 | 18,7366644 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 32 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 53,54663 | 18,7366644 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 33 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 55,04663 | 16,3366473 | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 34 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 53,54663 | 18,736662  | Төрийн өмч | 2007 | 2008 | 6  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | дунд | тийм |
| 35 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ 100 км   | 4320 | 68000  | сайн | тийм |
| 36 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ 100 км   | 4320 | 68000  | сайн | тийм |
| 37 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ 100 км   | 4320 | 68000  | сайн | тийм |
| 38 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | сайн | тийм |
| 39 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ 100 км   | 4320 | 68000  | сайн | тийм |
| 40 | ХОВО     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | сайн | тийм |
| 41 | ХОВО     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 62,27028 | 43,0079161 | Төрийн өмч | 2011 | 2011 | 3  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | сайн | тийм |
| 42 | хово     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 67,05026 | 55,3366637 | Төрийн өмч | 2012 | 2012 | 2  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | сайн | тийм |
| 43 | ХОВО     | Өөрөө буулгагч | 3257       | Хятад    | тн  | 20   | 67,05026 | 55,3366637 | Төрийн өмч | 2012 | 2012 | 2  | - | - | 38л/ ЮОкм     | 4320 | 68000  | сайн | тийм |

|    |             |                |             |       |    |     |          |            |            |      |      |    |   |   |             |      |       |      |      |
|----|-------------|----------------|-------------|-------|----|-----|----------|------------|------------|------|------|----|---|---|-------------|------|-------|------|------|
| 44 | ХОВО        | Өөрөө буулгагч | 3257        | Хятад | тн | 20  | 67,05026 | 55,3366637 | Төрийн өмч | 2012 | 2012 | 2  | - | - | 38л/ЮОкм    | 4320 | 68000 | сайн | тийм |
| 45 | ХОВО        | Өөрөө буулгагч | 3257        | Хятад | ТН | 20  | 67,05026 | 55,3366637 | Төрийн өмч | 2012 | 2012 | 2  | - | - | 38л/ЮОкм    | 4320 | 68000 | сайн | тийм |
| 46 | КамАЗ-53512 | Автокран       | КС-55713-1К | ОХУ   | ТН | 25  | 137,8466 | 36,8930786 | Төрийн өмч | 2007 | 2007 | 7  | - | - | 47л/ЮОкм,   | 2112 | 11280 | дунд | тийм |
| 47 | КрАЗ-256    | Автокран       | КС-4561А    | ОХУ   | ТН | 17  | 1,130435 | 0,04368485 | Төрийн өмч | 1984 | 1990 | 24 | - | - | 59л/ЮОкм,   | 2112 | 14160 | дунд | тийм |
| 48 | Зил-130     | Автовышка      | АГП-22      | ОХУ   | КГ | 300 | 16,11282 | 0          | Төрийн өмч | 2003 | 2003 | 11 | - | - | 40,2л/ЮОкм, | 2112 | 10353 | дунд | тийм |
| 49 | Зил-130     | ТМ тээвэрэлч   | ачааны      | ОХУ   | ТН | 5   | 48,5     | 36,64      | Төрийн өмч | 2007 | 2007 | 7  | - | - | 40,2л/ЮОкм, | 3600 | 45000 | сайн | тийм |

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### Голлох сөрөг нөлөөлөл

#### I. Хөрсний элэгдэл-эвдрэл бохирдол

Бор-Өндөр, Адагийн хайлуур жоншны бүлэг ордод хүдрийн биетийн байршил, орших гүн, ордын төрөл, нөөцийн хэмжээ зэргээс хамаарч ил ба далд аргыг хослуулах замаар олборлолт явуулж ирсэн.

Хөрс хуулалт уурхайн малталтаар газрын хэвлийд томоохон орон зай үүсэхийн сацуу ойр орчмын харьцангуй тэгшхэн газруудад үржил шимт хөрс, хурдас чулуулгийн овоолгууд байгуулж, хүдэр тээвэрлэлтээр хөрс зурваслан ургамалгүй болж нүцгэрэн элэгдэж эвдэрсэн. Цаашлаад уурхай үйлдвэрийн ажлын бүсэд ачиж буулгах, ялгах зэрэг үйл ажиллагаанд хөрс дундаас хүчтэй эвдрэлд орсон байна.

2008-2015 онд уурхайн малталт, овоолго байгуулах, уурхайн ашиглалтаар эвдрэлд орсон талбайн нийт хэмжээ Бор-Өндөрийн ордод 268,98 га, Адагийн ордод 74,91 га байна. Энд хатуу хог хаягдлаар бохирдсон, хаягдлын сан дор орсон талбай, тоосонд дундаас хүчтэй өртсөн талбайг хамааруулж авч үзээгүй болно.

Хаягдлын сангийн зүүн талаар далангийн биртүүдийг өндөрлөх ажил хийгдээгүй олон жил болж байгаа нь элс хийсч хунгарласаар даланг давж овоорсон, сангийн хуурай гадаргуугаас хийсэх элс салхины зонхилох чиглэл дагуу зүүн урагш хамгийн их талбайд хийсэн тархахын зэрэгцээ сангийн өмнө талын ухааг даван дэнж дэвсэг дээгүүр хөрс жигд зузаантайгаар элсээр хучигдсан байна. Хаягдлын сангийн талбайн төв хэсгийг эс тооцвоос өмнө, зүүн болон баруун хэсэгт булинга хатаж хуурайшсанаас тоосны томоохон эх үүсвэр болсоор байна.

Хаягдлын санд 148,07 га талбай хамрагдахаас гадна хаягдлын сангаас хийсэх тоосонцор элсэнд янз бүрийн зузаантайгаар дарагдсан, хучигдсан, бүрхэгдсэн талбайн хэмжээ 1956,5 га байна.

Бор-Өндөр УБҮ нь 2020 онд хаягдлын даланг сайжруулан өндөрлөх ажлыг гүйцэтгэсэн. Иймд ирэх онуудад элс хийсч хунгарлах даланг давах зэрэг эрсдэл үүсэхгүй байх үүднээс тус талбайн салхин дээд талд нь мод тарих ажлыг ирэх оноос эрчимжүүлэхээр төлөвлөж байна. Одоогоор нийт 4000 ширхэг мод тарьсан.

#### **Дүгнэлт:**

Бор-Өндөрийн уурхай орчмын хөрсний дээжид хийсэн лаборторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хортой химийн элементүүд болох хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), никель (Ni), цайрын (Zn) агуулга нь энэ хавь газарт нийтлэг элсэнцэр ширхэгийн бүрэлдэхүүнтэй хөрсний Үндэсний стандартын (MNS 5850:2008) зөвшөөрөгдөх агууламжийн хэмжээнд хүрээгүй, бага тоон үзүүлэлтээр илэрч байгаа нь эдгээр органик биш бохирдуулагч элементээр хөрс бохирдоогүй болохыг харуулж байна.

Харин УБҮ-ийн хашаан доторх бохирдсон хөрсний зарим дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс үзвэл хүлцэх хэмжээнээс хар тугалга 2,3 дахин, кадмий 1,4 дахин их бохирдолттой гарч байна.



Хаягдлын сангийн урдуур үргэлжлэх ухаагийн орой буюу дэнж дэвсэг газраар тогтворжсон сайргархаг элсэнцэр хүрэн хөрсний гадарга дээр усан сангийн захаас хийсч тогтсон хучаас элсэн дахь хар тугалга (55,3-57,7 мг/кг), кадмийн агуулга (1,01 мг/кг) буюу хүлцэх агууламжаас бага зэрэг давсан тоон үзүүлэлттэй байгаа нь уурхайн хаягдлын санд тунасан тоосонцор элсээр хөрс бохирдож эхэлж байгаагийн илрэл болно.

## **II. Агаарын бохирдол**

Уулын баяжуулах үйлдвэр, одоо ашиглалт явуулж байгаа далд уурхайн ашиглалтаас агаарт хамгийн их нөлөөлөл үзүүлж байгаа объект бол тунгаан цэвэршүүлэх замаар эргэлтээр ашиглаж байгаа хаягдлын санд нийлүүлж буй технологийн шингэн хаягдал болно.

Хаягдлын сангийн гадаргуу байнгын чийгтэй байх боломжгүйгээс тэнд хуримтландсан лаг шавар хатаж, тоосонцор элс хийсэн тархах эх үүсвэр болсоор олон арван жил болж байна. Хаягдлын сангийн талбайн тоос босох хуурай хэсгийн талбай жил жилээр улам бүр нэмэгдэн нарийн ширхэгтэй элс шороо салхины зонхилор чиглэл дагуу зүүн, зүүн урагш, урагш хийссээр нутгийн малын бэлчээрт үүсмэл цөлжилтийг бий болгоод байна.

Бор-Өндөр УБҮ нь 2023 онд Дулааны станц, Баяжуулах фабрик цехүүдэд тус бүрд нь БОНБНҮ хийлгэж сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### **Дүгнэлт:**

Тоосны агууламж тодорхойлох хэмжилтийг УБҮ-ийн хамгийн тоостой цех дамжлагууд, үйлдвэрийн гадаа ажлын бүс, хүдэр тээвэрлэлтийн зам, далд уурхай, үйлдвэрийн хаягдлын сан, вагон буулгах ачих талбай зэрэг нийт 12 цэгт хийсэн.

УБҮ-ийн том, дунд, бага бутлуурын оролт, гаралт дээр 2,07-54,8 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 20,7-548,8 дахин их байна.

Үйлдвэрийн харьцангуй бага тоосны бохирдолттой гэж хэлж болох баяжуулах болон үйдвэрийн эцсийн бүтээгдэхүүн савлах цех хэсгүүд дээр тоосны агууламж 0,488-0,798 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 4,9-8,0 дахин их байна. Иймээс УБҮ-ийн үндсэн цех дамжлагууд нийтдээ тоосны бохирдолттой гэж хэлж болно.

УБҮ-ийн хаягдлын сан орчимд салхи тогтуун үед хийсэн хэмжилтээс харвал тоосны агууламж 0,461 мг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх хэмжээнээс 4,6 дахин их байна. Хаягдлын сан бол тоосны томоохон эх үүсвэрийн хувьд байнгын тоосролттой төдийгүй, тоосны хөрсөн буух, тархалтын зон жилээс жилд тэлсээр байна.

## **III. Гадаргын ба газрын доорх ус**

### **Гадаргын ус**

Адаг, Бор-Өндөрийн хайлуур жоншны орд орчмын талбай нь Төв азийн гадагш урсацгүй ай савд хамаарах бөгөөд Хэнтийн нурууны салбар уулс Сүмбэр, Чойрын богд, Сансар уулсын усны хагалбараар зааглагдана. Бор-Өндөрт 1982, Адагт 1987 оноос хойш 30-аад жилд хайлуур жоншны олборлох үйл ажиллагаа явагдаж байна. Энэ бүс нутаг гадаргын байнгын урсацгүй, хуурай хээрийн бүсэд хамаарна. Өвөл хуримтлагдсан цас

хайлах, зуны аадар бороо орох үеэр олон тооны хуурай сайраар түр зуурын үер ажиглагдана.

Адагийн уурхай нь уул, толгодийн оройд байрлах учир хур борооны үерт автахааргүй юм. Харин Адагийн ордыг дахин ашиглавал ашиглах явцад гарч байгаа тоос шороо Бор-Өндөрийн УБҮ-ийн чиглэлд салхины урсгалаар туугдан хөрс, агаарыг бохирдуулж сумын төвийн оршин суугчид болон орчны экологийн байдалд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Бор-Өндөрийн баяжуулах үйлдвэр өөрийн хүч хөрөнгөөр сайрын гулдрилиг нийтэд нь хаасан шороон далан хийж, борооны үерийн усыг үйлдвэрлэл явуулж байгаа талбайгаас зайлуулах гидротехникийн арга хэмжээ авсан байдаг.

### **Газрын доорх ус**

Хоорондоо 13 км орчим зайтай орших Бор-Өндөр, Адагийн хайлуур жоншны орд орчмын талбай нь усзүйн хувьд газар доорх усны нөөц зонхилсон Умард говийн гүвээт халхын дундад тал сав газар болон Хэрлэн голын ай сав газрын зааг дээр оршдог.

Энэхүү сав газарт ашиглах бололцоотой газар доорх усны нөөц гэдэг нь олон жилийн туршид хуримтлагдсан нөхөн тэжээгддэггүй газар доорх усны нөөцөөс бүрддэг гидрогеологийн мужлалын 3-р эрэмбийн гидрогеологийн массивд хуримтлагдсан бөгөөд үндсэндээ Монгол орны хээрийн бүсэд оршдог учраас энд жилд унах хур тунадас багавтар бөгөөд ууршилт унах хур тундасаас даруй давдаг байна. Өөрөөр хэлбэл, энд гадаргын усан сүлжээ муутай бөгөөд ихэвчлэн газар доорх ус тархсан байдаг.

Бор-Өндөрийн УБҮ-ийн хэсэгт геологи хайгуулын судалгааны үе шатаас эхлэн өнөөг хүртэлх (1980-2020) ашиглалтын олон жилийн хугацаанд хүдэр олборлолт, баяжуулалтын технологийн онцог, уулын ажлын цар хүрээнээс хамаарч, хүрээлэн буй байгаль орчиндоо зохисгүй нөлөө үзүүлэх урьдчилсан бодит байдлууд гидрогеологи, инженер-геологийн нөхцлийн талаасаа бүрдсэн байна. Эдгээр нөхцлүүд нь газар доорх усны гидродинамикийн зүй тогтлуудтай уялдаж үүсдэг онцлогтой. Ялангуяа гүний далд уурхайд хүдэр олборлолтын үеийн тэсэлгээ, ордын усыг шүүрүүлэн зайлуулах болон хүдэр баяжуулах технологи, үйлдвэрийн шингэн хаягдлын сан зэрэг техноген үйл явцын үр дүнд бий болсон байгаль орчны зохисгүй өөрчлөлт нь дараах байдлаар илэрч байна.

1. Уурхайн ашиглалтын үед гүний усыг гадагш их хэмжээгээр шүүрүүлсний улмаас газрын доорх усны байгалийн статик нөөц барагдаж, хамрагдах талбайн хэмжээндээ газрын чийг хатаж, агааржилтын бүс хуурайшсан.
2. Агааржилтын бүсээр дамжин үүсдэг гадаргын ба газрын доорх усны харилцан холбоо шүтэлцээний горимд үндсэн өөрчлөлт орсон.
3. Уулын цуллагт геостатик ба гидростатик даралт өөрчлөгдөж, хөрсний усны шүүрэлтийн градиент алдагдсаныг үндсэн чулуулгийг хучиж тогтсон сэвсгэр хурдсанд суффозын үзэгдэл явагдаж, хөрсний суулт (просадка) хотойлт УБҮ-ийн захиргааны байрын баруун, баруун хойд хэсэгт үүссэн.
4. Газрын доорх усны байгалийн түвшингийн байрлалд эрс өөрчлөлт орж, нилээд талбайд газрын доорх усны түвшингийн бууралт хүнхээл үүссэн бөгөөд үүний төв цэгтээ усны түвшингийн бууралт гадаргуугаас доош 240-250м-ийн гүнд тогтоогдож байна. Энэ нь газар доорх усны хөдөлгөөний байгалийн төрх горим үндсэндээ өөрчлөгдсөнийг харуулна. баяжуулах фабрикийн технологид

хэрэглэгдэж буй шүүрлийн ус нь микроэлементийн агуулга 2015 онд 2008 оны үеийнхтэй ойролцоо, усны эрдэсжилт 1999 оныхоос бага буюу 447мг/л байгаа нь гадаргуугаас доош нэвчин ан цавын усанд нөлөөлөх хүчин зүйл алга байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл хаягдлын сан зэрэг гүний ус бохирдуулах байгууламжийн ёроол шавар лагаар хучигдсан нь бохирдол доош шүүрэх боломжгүй болгожээ.

#### **IV. Ургамлан нөмрөгийн өөрчлөлт, амьтны аймагт нөлөөлөх хүчин зүйлс**

##### **Ургамлан нөмрөг:**

Төслийн талбай орчмын газар нутгийн ургамалжил байгалийн дулаарал, хуурайшлаас гадна 30 гаруй жил явагдаж байгаа уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, жилээс жилд энд суурьшил нэмэгдэж байгаа зэргээс багаас хүчтэй талхлагдалтад орж, бодит өөрчлөлт, сөрөг үр дагавар гараад байна.

Үйлдвэрийн хаягдлын сангаас хийсэх тоосонцор элс 1956,45 га талбайг янз бүрийн зузаантайгаар хучаад байна. Хаягдлын сангаас зүүн, зүүн урагш, урд талаар 652,15 га талбайн ургамал нөмрөг гадаргуугийн хотгор гүдгэрээс хамаарч 25-10 см, зарим газартаа үүнээс ч илүү зузаантайгаар элсэнд бүрэн хучигдсан. Ийнхүү хаягдлын сангаас хийсэх тоосны хамрах талбай, ургамлан нөмрөгийг бүрхэх зузаан улам ихэсч байна.

Түүнчлэн хөрс хуулалт, хөрс сулралт, олборлолт, овоолго байгуулах, хүдэр тээвэрлэлт, баяжуулах үйлдвэрийн технологи ажиллагаанаас үүссэн агаар дахь тоос шороо нь орчны хөрс ургамал дээр харилцан адилгүй зайнд бууж, ургамлын бүрхэвчийг нимгэн үеэр тоос бүрж, ургамлын бодисын солилцоо болох фотосинтез тодорхой түвшинд зогсонги байдалд орон ургамал сийрэг, давжаа болох тал ажиглагдаж байна.

##### **Амьтны аймаг:**

Бор-Өндөр сумын төв, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Адаг, Бор-Өндөрийн уурхайн орчны зэрлэг хөхтөн амьтдын нүүдэл, хөдөлгөөнд саад болох, махан идэшт амьтдын дэлгэц нутаг тасарч хумигдана. Үүнтэй дасан зохицох амьтдын хоногийн идэвх нь шөнийн цагаар үргэлжилнэ.

Улаан овооны Адаг уул нь Чойрын Богд уулаас аргал нүүдэллэх коридор нутаг бөгөөд Адагийн хайлуур жоншны бүлэг ордын ашиглалтаар үүсч буй уурхайн малталтууд ба гадаад овоолгууд нь энэ замыг хумих, цаашид ашиглалт идэвхжсэнээр аргалын нүүдэл хөдөлгөөн тасрах нөхцөл бүрдэж болно.

Уурхайн ашиглалтын явцад энэ орчинд байгаа бусад хөхтөн амьтдын амьдрах орчин өөрчлөгдөх, идэш тэжээл ховордох, үхэж үрэгдэх, дайжих зэрэг хүний үйл ажиллагаатай холбогдсон шууд болон дам нөлөөлөл тодорхой хэмжээгээр бий болсон. Цаашид ч бий болно.

Хөрс чулуулгийн овоолго байгуулах, хүдэр тээвэрлэх зэрэг машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх зэргээс ургамал нөмрөг талхлагдаж, хөрсний эвдрэл үүсч, улмаар тэр хэсгийн байгалийн тэнцвэр алдагдан амьтад нэн ялангяа хөрсний бичил амьтдад үзүүлэх нөлөө ихэсч байна.

Дээрх нөлөөлөл нь томоохон хөхтөн амьтдад шууд нөлөө үзүүлэх ба мэрэгч, шувуу, хоёр нутагтан, мөлхөгч, хавьжийн бүлгэмдэлд дам нөлөөлөлтэй байна. Зүйлийн

бүрдлийн хомсдол, тоо толгойн бууралт зэрэг шууд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл ашиглалтын үед огцом илрэхгүй.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Бор-Өндөр MV-000174 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт |  |   |  |           |                                |
|--|--|---|--|-----------|--------------------------------|
| ДД/д   | Үзүүлэлт   | Төлөвлөсөн ажил   | Гүйцэтгэл  | /сая.төг/ |                                |
| 1  | <b>I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b> | <b>Агаар</b>  |  |           | Үйл ажиллагааны зардалд орсон. |
|  |  | Салаа зам гаргахаас сэргийлж ухуулга сурталчилгааны самбар замын тэмдэг тэмдэглэгээ хийж мөрдүүлэх  | Зам ашиглалтын хяналтаар сайжруулах шаардлагатай газруудад хэсэгчилсэн сайжруулалтыг хийсэн. Нийт 14 замын тэмдэглэгээ тавьсан. Тээвэрлэлтийн нэгдсэн 1 замтай.                                      |           |                                |
|  |  | Ажилчдыг физик химийн бохирдлоос урьдчилан сэргийлэх талын мэдээллээр хангаж сургалтад хамруулах  | Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж ажилласан. ХАБЭА-ийн 12 цагийн сургалтанд нийт ажилчид хамрагдсан.  |           |                                |
|  |  | Уурхайн ажилдагсдыг эрүүл мэндийн урьдчилсан ба цаг үеийн хугацаат үзлэгт тогтмол хамруулж байх   | Нийт ажилдагсдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт тогтмол хамруулдаг. Мөн Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2023 оны 9 сард төлөвлөгөөт үзлэг хийсэн.  |           |                                |
|  |  | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх | 2023 оны 5 болон 7 дугаар саруудад улсын техникийн үзлэгт бүх техник машинуудыг хамруулсан. Нийт тээврийн хэрэгслүүдэд өдөр бүр механикууд үзлэг хийж шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийдэг. |           |                                |
|  |  | Гүний уурхайн тэсэлгээ, хүдэр олборлох явцад үүсэх тоосыг намжаасны дараа хүмүүсийг ажиллуулах  | Гүний уурхайн тэсэлгээ, хүдэр олборлох явцад үүсэх тоос, хорт бодис намжаасны дараа буюу УБҮ-ийн аврах ангийн алба хаагч нар 1-2 цагийн дараа орж хяналт шалгалт хийсний дараа ажилчдыг ажиллуулдаг. |           |                                |
|  |  | Төсөл хэрэгжих талбайн гадна болон дотор талд тоосжилтын төвшин болон ширхэглэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хянах цэг байгуулах                       | Орчны хяналт шинжилгээ хөтөлбөрийн дагуу тоосжилтын төвшин хэмжих 7 цэгийг байгуулсан.   |           |                                |

|             |  |  |  |                                |
|-------------|--|--|--|--------------------------------|
|             |  | Зам дагуу болон уурхайн малталтуудын орчмын эвдэрсэн хөрсийг дүүргэлт хийн тэгшлэх, ойр хавийг хог хаягдлыг цэвэрлэх       | Уурхайн ойр орчимд суулт үүссэн болон эвдэрсэн газруудад пород болон шимт хөрс ашиглан тэгшлэх арга хэмжээг авч ажилладаг. Сар бүр цэвэрлэгээг тогтмол хийдэг. Сумын ЗДТГ болон төр захиргааны байгууллагаас ирж байгаа зөвлөмжийн дагуу цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилладаг.           |                                |
| <b>Хөрс</b> |  |  |  |                                |
|             |  | Тоосжилт гаргахгүй байх үүднээс ачаалал ихтэй замуудыг услах   | Замыг тогтоосон хуваарийн дагуу 7 хоногт 4 удаа, зарим тохиолдолд өдөр бүр усалгаа хийгддэг.   | Үйл ажиллагааны зардалд орсон. |
|             |  | Машин механизмын шатах тослох материал хадгалах ашиглах дүрэм журмыг чанд сахих  | Ажилчидыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулдаг. Норм стандартын дагуу хадгалах, ашиглах ХАБЭА-ийн зөвлөмжийг мөрдөн ажилладаг. Мөн ашигласан шатах тослох материалыг тусгай зориулалтын түр хадгалах агуулахад хадгалж тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэн ажилдаг. |                                |
| <b>Ус</b>   |  |  |  |                                |
|             |  | Зөөврийн усыг ангилан нөөцлөх шаардлага хангасан савтай байх / Унд ахуйд болон зам усалгаанд тусдаа нөөцлүүр савтай байх / | -Унд ахуйн 4*2000 нөөцлүүр савтай<br>-Зам усалгаа хийх 2-10 тонны 3 машинтай.<br>Хуваарийн дагуу усалгаа хийх үед УБҮ-ийн технологийн ус дамжуулах системээс ус авч усалгааг хийдэг.   | Үйл ажиллагааны зардалд орсон. |
|             |  | Ус нөөцлөх савны эрүүл ахуйн байдалд онцгой хяналт тавьж ажиллах   | УБҮ-ийн Эрүүл ахуйч мэргэжилтэний зөвлөмж зааврын дагуу Усны нөөцлөх савыг жилд 1 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг хийдэг.   |                                |
|             |  | Төслийн талбай, нөлөөллийн бүс орчмын ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанарт хяналт тавьж ажиллах.                 | Хэнтий аймгийн эрүүл мэндийн газрын улсын байцаагчаар жилд 2 удаа 8 цэгээс усны дээжид 19 үзүүлэлт бүхий шинжилгээ хийсэн. Мөн Орчны хяналт шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд жилд 2 удаа усны   |                                |

|   |  |  |   |                                |
|---|--|--|---|--------------------------------|
|   |  |  | дэлгэрэнгүй шинжилгээ хийлгэн ажиллаж байна.  |                                |
|   |  | <b>Ургамал, амьтан бусад</b>   |   |                                |
|   |  | Ургамлан бүрхэвч үүсэхэд нөлөө бүхий бут сөөг болох Хайлаас, харгана, тавилгана, нохойн хошуу зэргийг бөөнөөр буюу бүлэглэж суулгах зэргээр хослон тарих   | “Бор-Өндөр” УБҮ-ийн ногоон байгууламж болон дүйцүүлэн хамгаалах талбайд хайлаас, шар хуайс, улиас зэрэг 24500 ширхэг моднуудыг тарьсан. Мөн 2021 онд хүлэмжинд үрээр тарьж бойжуулсан 4000 ширхэг агч модыг гарган тарьсан. | Үйл ажиллагааны зардалд орсон. |
|   |  | Төслийн талбай түүний ойр орчмын хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлаас мал амьтан хордож болзошгүй учир үүнээс сэргийлж хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах хэрэгтэй     | - Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ ОНТҮГ-тай 2023 оны 03 сарын 06-ны өдрийн ВУ-2023-04-02 тоот гэрээ байгуулан дахивар болон хог хаягдлын цэг рүү 7 хоногт 4 удаа ачиж зайлуулж байна.  |                                |
| 2 | <b>II. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</b> | Бор-Өндөр УБҮ-ийн MV-000174 тусгай зөвшөөрөлтэй талбайн гадна, тосгон хүрэх ЗАМЫН УРД хэсэгт ногоон байгууламж байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. <b>Луурхайн нөлөөллийн бүс бөгөөд нэг экосистемтэй болно.</b> Тус талбайд 10000 ширхэг Хайлаас, Агч модны суулгац тариална. | Бор-Өндөр УБҮ-ийн замын урд талын хэсэг дэх ногоон байгууламжид нийт 8 га талбайд 24500 ширхэг “Хайлаас, Шар хуайс, Улиас, 4000 Агч зэрэг модны суулгацуудыг тарьж ургуулсан.   | 66,0                           |
|   |  | Бор-Өндөр УБҮ-ийн Баяжуулах фабрик, ХАЯГДЛЫН АЖ АХУЙН хэсэг дэх, ногоон байгууламжид 1000 ширхэг хайлаас мод тариална.   | Бор-Өндөр УБҮ-ийн Баяжуулах фабрик, ХАЯГДЛЫН АЖ АХУЙН хэсэг дэх, ногоон байгууламжид 6000 ширхэг хайлаас, шар хуайс, зэрэг моднуудыг тариалсан.<br><br>/Хавсралт/   |                                |

|   |   |  |  |                                |
|---|---|--|--|--------------------------------|
|   |   | Бэрх тосгонд техникийн нөхөн сэргээлт хийсэн 11,2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх   | 2023 онд нийт 11,2 га талбайд олон наст ургамлын үрний тариалалт хийсэн. Мөн 2650 ширхэг хайлаас, шар хуайс, улиас агч моднуудыг тариалсан.<br>/Хавсралт-/   |                                |
| 3 | <b>III.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө</b> | <u>Уурхайн нөлөөллийн бүсэд малчин өрх байхгүй бөгөөд тухайн жилд холбогдох асуудлаар ямар нэгэн зөрчил болон өргөдөл гомдол гарсан тохиолдолд хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.</u>  | Энэхүү асуудлаар ямар нэгэн өргөдөл, гомдол гараагүй.  | -                              |
| 4 | <b>IV. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</b>           | Тухайн жилийн олборлолтын үйл ажиллагааны явцад түүх соёлын үнэт өв, олдворын зүйл илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.   | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй.   | -                              |
| 5 | <b>V. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</b>                  | <ul style="list-style-type: none"> <li>➢ Химийн бодисын Хор, аюулын тэмдэглэгээг латин “Н” үсгийн ард бичигдсэн 3 оронтой тоо бүхий код-оор илэрхийлж физик, эрүүл мэндэд үзүүлэх хор аюул, байгаль орчинд үзүүлэх хор аюулын тэмдэглэгээ хийх</li> <li>➢ Химийн бодисуудтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа, санамсаргүй асгарч алдагдсан үед болон гал унтраах, устгал хийхэд авах арга хэмжээ, мөн химийн бодисуудаар хордох замууд, эрсдэл тохиолдохоос сэргийлэх тэмдэглэгээг латин “Р” үсгийн ард бичигдсэн 3 оронтой тоо бүхий кодоор илэхийлэх тэмдэгжүүлэх</li> <li>➢ Үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөөний дагуу ажиллах, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж, зөвлөгөөг хэрэгжүүлэх</li> <li>➢ Шатах тослох материал, тэсрэх болон химийн бодисын агуулах, тэдгээрээр үйлчилгээ явуулах анхан шатны ажил үйлчилгээнд мэргэжилтний заавар зөвлөгөөн, хяналтын дор мэргэжлийн юмуу сургалт семинарт хамрагдсан, олон жил</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Тэмдэглэгээг байршуулсан</li> <li>➢ Тэмдэг тэмдэглэгээг байршуулсан</li> <li>➢ Үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөөний дагуу Бор-Өндөр сумын Онцгой байдлын 49 дүгээр ангитай хамтран аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үзүүлэх сургалтыг УБҮ дээр зохион байгуулсан.</li> <li>➢ Шатах тослох материал, тэсрэх болон химийн бодисын агуулах, тэдгээрээр үйлчилгээ явуулах анхан шатны ажил үйлчилгээг МХЕГ-ын хамтарсан ажлын хэсгийн үзлэг шалгалт хийгдсэн ба илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</li> <li>➢ Химийн болон тэсрэх материалын бүхий л шатны үйл ажиллагаанд Үйлдвэрийн ХАБЭА хяналтын I-IV шатны үзлэгийг зохион байгуулж ажилласан.</li> <li>➢ Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоож болзошгүй эрсдэлээс сэргийлж ажилласан.</li> <li>➢ АТЦ-д ашиглагдаж байгаа машинуудыг битүүмжлэл сайтай болгосон</li> </ul> | Үйл ажиллагааны зардалд орсон. |



|  |  |  |  |
|--|--|--|--|
|  | <p>ажиллаж дадлага туршлага олж авсан хүнийг ажиллуулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Химийн болон тэсрэх материалын бүхий л шатны үйл ажиллагаанд Үйлдвэрийн ХАБЭА хяналтын I-IV шатны үзлэгийг зохион байгуулан шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, дүн шинжилгээ хийх.</li> <li>➢ Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох</li> <li>➢ Автомашинуудыг кабиныг битүүмжлэл сайтай болгох</li> <li>➢ Шаардлагатай газруудад аянга зайлуулагч суурилуулах</li> <li>➢ Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох</li> <li>➢ Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах</li> <li>➢ Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах</li> <li>➢ Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрт байрлуулах</li> <li>➢ Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах,</li> <li>➢ Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах</li> <li>➢ Жолооч бүрийг даатгалд хамруулах</li> <li>➢ Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах</li> <li>➢ Тэсрэх бодисын шинж чанар дээр үндэслэн бодисын нэр томьёо, худалдааны болон техникийн нэр, олон улсын бүртгэлийн дугаар, ашиглах газар, зориулалт, хугацаа, тоо хэмжээ, болзошгүй</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Шаардлагатай газруудад аянга зайлуулагч суурилуулсан.</li> <li>➢ Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоож болзошгүй эрсдэлээс сэргийлж ажилласан.</li> <li>➢ Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол танилцуулж ажилласан.</li> <li>➢ Тухайн жилийн төлөвлөгөөт /хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны/ сургалтыг зохион байгуулсан.</li> <li>➢ Осол аваараас урьдчилан сэргийлэх анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрт байрлуулсан.</li> <li>➢ Жолооч нарыг аюулгүй ажиллагааны төлөвлөгөөт сургалтанд хамруулсан.</li> <li>➢ Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан.</li> <li>➢ Жолооч бүрийг даатгалд хамруулсан.</li> <li>➢ Тэсрэх бодис боловсруулах болон тээвэрлэлтийн машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулсан.</li> </ul> <p>Тэсрэх бодистой харьцаж ажилладаг ажилчдыг ээлжит сургалтанд хамруулж ажил эхлэхийн өмнө давтан зааварчилгаа өгч ажилласан.</p> |  |
|--|--|--|--|

|   |  |  |  |                                |
|---|--|--|--|--------------------------------|
|   |  | ослын үед авах арга хэмжээ, тухайн бодис, хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга зэргийг агуулсан лавлагааг мэдээллийг тэсрэх бодистой харьцаж ажилладаг ажилчдад танилцуулах   |  |                                |
| 6 | <b>VI. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө</b> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар тэмдэгжүүлэлтэй болох</li> <li>➢ Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байх</li> <li>➢ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах</li> <li>➢ Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах</li> <li>➢ Дугуй, модны хаягдлыг дахин ашиглах, орон нутгийн хэрэгцээнд өгөх</li> <li>➢ Автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах</li> <li>➢ Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох</li> <li>➢ Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах</li> <li>➢ Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулах, 2-догч түүхий эд авах цэгт тушаах</li> <li>➢ Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхлэдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх.</li> <li>➢ Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах</li> <li>➢ Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумын “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-тай гэрээ байгуулан зайлуулах</li> <li>➢ Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Самбар тэмдэгжүүлэлтийг байршуулсан.</li> <li>➢ Ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг тогтмол авч байна.</li> <li>➢ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах цэгээс “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ОНТӨҮГ-аар тээвэрлүүлж ажилласан. Цех бүрт 3 ангилан ялгах сав байршуулсан. / Дахивар хог хаягдлаар хийсэн /</li> <li>➢ Хуванцар савыг Хог хаягдал дахин боловсруулах аж ахуй нэгжүүдэд гэрээгээр нийлүүлсэн.</li> <li>➢ Дугуйны хаягдлыг УБУ-ийн автозогсоолын талбайд ашигласан. Замын хойд талд шинээр авто зогсоол хийсэн.</li> <li>➢ Автомашины сэлбэг, төмрийн хаягдал 2-догч түүхий эдийг “Хаягдал төмөр худалдан авах гэрээгээр” гэрээлэн нийлүүлсэн. /Гэрээг хавсаргав./</li> <li>➢ Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг хувиараа аж ахуй эрхэлдэг иргэдэд өгдөг.</li> <li>➢ Боломжтой хог хаягдлын дахин ашиглалт хийж “Ногоон Эко булан” байгуулсан Мөн Хог хаягдлыг дахин ашиглах сургалтыг Хэнтий аймгийн Боловсролын салбарын хэмжээнд зохион байгуулсан.</li> <li>➢ Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулах, 2-догч түүхий эд авах цэг, ААН-тэй гэрээ байгуулан 2 удаа нийт 10 тн тос масло нийлүүлсэн.</li> <li>➢ Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэдэг “Түмэн эгшиг” ХХК, “Хэ</li> </ul> | Үйл ажиллагааны зардалд орсон. |

|   |  |   |  |                                       |
|---|--|---|--|---------------------------------------|
|   |  | <p>хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.</p>   | <p>би ойл” ХХК, “Эко минерал” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. /Гэрээ, холбогдох материалыг хавсаргав./</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Уурхайн ажилчдыг мэргэжлийн сургалтаар хангасан. Цахим орчинд холбогдох мэдээллийг байршуулан ажилласан. Хог хаягдлын зөвлөх үйлчилгээг авч менежментийг сайжруулсан. Мөн олон улсын чанарын стандартуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.</li> <li>➢ Хог хаягдлыг зайлуулах, “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-тай байгуулсан гэрээг хавсаргав.</li> </ul> <p>Аюултай хог хаягдлыг таних тэмдэг ХАЛМ-ыг ил харагдахуйц газар байршуулж хуримтлуулж эхэлсэн хугацааг бүртгэлжүүлсэн.</p> |                                       |
| 7 | <p><b>VII. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө</b></p> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг гаргах зорилгоор календарчилсан төлөвлөлт гаргаж мөрдөж ажиллах,</li> <li>➢ Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах, гэрээний дагуу төлбөр төлөх,</li> <li>➢ Сумын байгаль орчныг хамгаалах ажилд оролцоо, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах,</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>➢ Календарчилсан төлөвлөлт гарган гүйцэтгэлийг хангуулж ажилласан.</li> <li>➢ Үйлдвэрлэлийн болон ундны Ус, Ус бохирдуулсны дүгнэлтүүдийг БОАЖЯ-ны “Усны газар”-аар гаргуулан УГГХДТСГ, ХГСГ-ын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авсан. Зөвшөөрлийн дагуу гэрээ байгуулан төлбөрийг төсөвт төвлөрүүлэн ажилласан.</li> </ul> <p>Сумын байгаль орчныг хамгаалах ажлыг “Хамтран ажиллах гэрээ”-нд тусган, гүйцэтгэлийг хангаж ажилласан. /Гэрээ, холбогдох баримтыг хавсаргав./</p>  | <p>Үйл ажиллагааны зардалд орсон.</p> |

|   |  |  |   |                                       |
|---|--|--|---|---------------------------------------|
| 8 | <b>VIII. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө</b> | <p>➤ Тухайн жилийн байгаль орчны менежментийн /2023 оны/ төлөвлөгөөний хэрэгжилтийг дараа I болон II улиралд олон нийтэд тайлагнах</p> | <p>Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны II болон III-р улиралд олон нийтэд тайлагнаж сумын ИТХ-аар нэг удаа сумын Багийн хурлаар тус тус 1 удаа оруулж тайлагнаж ажилласан.</p>   | <p>Үйл ажиллагааны зардалд орсон.</p> |
| 9 | <b>IX. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр</b>  | <p>Орчны хяналт шинжилгээг тухайн жилд 2 удаа гүйцэтгүүлэх <u>/2023 оны 6 болон 9 дугаар сард/</u></p>                                 | <ul style="list-style-type: none"> <li>- Хяналт шинжилгээний 1 дэх удаагийн дээжлэлтийг Хэнтий аймгийн УЦУОШТ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн хооронд байгуулсан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ВU-2023-03-06 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу гүйцэтгүүлэн дүн шинжилгээг гаргуулсан.</li> <li>- Хяналт шинжилгээний 2 дэх удаагийн дээжлэлтийг “Гурван Орчил Мандал” ХХК болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн хооронд байгуулсан 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ВU-2023-03-17 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу гүйцэтгүүлэн дүн шинжилгээг гаргуулсан.</li> <li>- Хяналт шинжилгээний 3 дах удаагийн дээжлэлтийг “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газраас ирүүлсэн 2023 оны 10 дугаар сарын 10-ны №143 тоот албан бичгийн дагуу гүйцэтгүүлэн дүн шинжилгээг гаргуулсан.</li> </ul> <p>/Хавсралт-/</p> | <p>10,08</p>                          |

**Х. Нөхөн сэргээлтийн мэдээлэл**  
**Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэрсэн газрын**  
**нөхөн сэргээлтийн зардлын дүн**

| Д/д  | Зардлын утга  | Хэмжих нэгж        | Ажлын хэмжээ  | Ашиглагдах техник, тайлбар | Нэгж ажлын зардал, төг | Нийт зардал, сая.төг  |
|--|---|--------------------|---|----------------------------|------------------------|-----------------------|
| <b>Бэлтгэл ажлын зардал</b>                    |   |                    |   |                            |                        |                       |
| 1  | Нөхөн сэргээлтийн ажлын хөрөнгө оруулалтын зардал     | Сая.төг            | Шаардлагатай Хөрөнгө худалдан авахад зарцуулах зардал |                            |                        |                       |
| 2  | Байгаль орчны суурь төлөв байдлын шинжилгээний зардал | Сая.төг            | Тооцоогоор шаардлагатай судалгаа хийх зардал          |                            |                        |                       |
| 3  | Нөхөн сэргээлтийн ажлын төсөв боловсруулах зардал     | Сая.төг            | Нөхөн сэргээлтийн зардлын төсөвт өртгийн 3-5%         |                            |                        |                       |
| А. Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлын зардлын дүн |   |                    | <u>1+2+3</u>  |                            |                        |                       |
| <b>Техникийн нөхөн сэргээлтийн ажил</b>        |   |                    |   |                            |                        |                       |
| 4  | Шимт хөрсний үе давхаргыг хуулах, ачих, хадгалах      | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 5  | Хөрс тээвэрлэх  | Мян.м <sup>3</sup> |   | Погрузчик                  |                        |                       |
| 6  | Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх                    | Мян.м <sup>3</sup> | 13104   | Автосамосвал, бульдозер    |                        | Үйлдвэрлэлийн зардалд |
| 7  | Овоолгын талбайг хэлбэржүүлэн тэгшлэх, нягтаршуулах   | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 8  | Шимт хөрсөөр талбайг хучих                            | Мян.м <sup>3</sup> |   | Автосамосвал, бульдозер    |                        | Үйлдвэрлэлийн зардалд |
| 9  | Тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх   | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 10   | Овоолгын хажууг хэвгийжүүлэх, дэвсгэжүүлэх            | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 11   | Туслах байгууламж байгуулахад үүссэн овоолгыг тэгшлэх | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 12   | Ургамалжуулахад бэлтгэн хөрсийг нягтаршуулах          | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 13   | Хөрс боловсруулах, сайжруулах                         | Мян.м <sup>3</sup> |   |                            |                        |                       |
| 14   | Шимт хөрсийг хадгалах, хамгаалах                      |                    |   |                            |                        |                       |

|   |  |        |       |                        |  |      |
|---|--|--------|-------|------------------------|--|------|
| Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн           |  |        |       | 25,000                 |  |      |
| Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал        |  |        |       |                        |  |      |
| 15  | Бүрхэвч ургамал тарих  |        |       |                        |  |      |
| 16  | Олон наст ургамлын үр тарьж суулгах                            |        |       |                        |  |      |
| 17  | Ойжуулах   | Ширхэг | 10000 | Хайлаас,Агч, Шар хуайс |  | 50,0 |
| 18  | Усалгаа, арчилгаа, тордолт хийх                                |        |       | -                      |  |      |
|   | Усалгааны тоног, төхөөрөмж                                     |        |       | 78,73                  |  |      |
| Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн           |  |        |       | 200,8 сая.төг          |  |      |
| Хаалтын дараах хяналт-шинжилгээний ажлын зардал |  |        |       |                        |  |      |
| 19  | Нөхөн сэргээгдэж байгаа явцын хяналт-шинжилгээний ажлын зардал |        |       |                        |  |      |
| 20  | Орон нутагт хяналт-шинжилгээ хийх үлдээх Хөрөнгө               |        |       |                        |  |      |
| Хаалтын дараах хяналт шинжилгээний ажлын зардал |  |        |       | <u>(19-20)</u>         |  |      |
| НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН        |  |        |       |                        |  |      |

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН  
ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН  
МЭДЭЭ**

**1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ**

|                                |   |   |   |            |   |   |   |
|--------------------------------|---|---|---|------------|---|---|---|
| Регистрийн дугаар              | 2   | 5 | 5 | 0          | 4 | 6 | 6 |
| Аж ахуйн нэгж байгууллагын нэр | “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ |   |   |            |   |   |   |
| <b>Байршил</b>                 | <b>Нэр</b>                                      |   |   | <b>Код</b> |   |   |   |
| Аймаг, нийслэл                 | Хэнтий  |   |   |            |   |   |   |
| Сум, дүүрэг                    | Бор-Өндөр                                       |   |   |            |   |   |   |

**2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

|                                |   |   |   |   |   |   |  |
|--------------------------------|---|---|---|---|---|---|--|
| Тусгай зөвшөөрлийн дугаар      | 0   | 0 | 0 | 1 | 7 | 4 |  |
| Тусгай зөвшөөрлийн талбай, га  | 371   |   |   |   |   |   |  |
| Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр | 1   | 9 | 8 | 1 |   |   |  |
| Ашигт малтмалын төрөл          | Хайлуур жонш  |   |   |   |   |   |  |
| Ашиглалтын төрөл               | Далд уурхайн аргаар, өрөмдлөг тэсэлгээний ажлаар нурааж, олборлон баяжуулах |   |   |   |   |   |  |

**3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ**

| Үзүүлэлт  | МД       | Хэмжих нэгж | Нийт     | Тайлант онд /ашиглалт/ |
|---|----------|-------------|----------|------------------------|
| <b>А</b>  | <b>Б</b> | <b>В</b>    | <b>1</b> | <b>2</b>               |
| Олборлолтод өртсөн нийт талбай                          | 1        | га          | 125.18   |                        |
| Ашигласан талбай  | 2        | га          | 62.59    |                        |
|   | 3        | мян.м³      | 6067.9   |                        |
| Хаягдал чулуулгийн овоолго                              | 4        | га          | 36.29    |                        |
|   | 5        | мян.м³      | 1971.266 |                        |
| Хөрсний овоолго   | 6        | га          | -        |                        |
|   | 7        | мян.м³      | -        |                        |
| Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар | 8        | га          | 26.3     |                        |
| Бусад   | 9        | га          |          |                        |

#### 4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ


| Үзүүлэлт   | МД       | Хэмжих нэгж        | Нийт     | Техник   | Биологи                  |
|--|----------|--------------------|----------|----------|--------------------------|
| <b>А</b>   | <b>Б</b> | <b>В</b>           | <b>1</b> | <b>2</b> | <b>3</b>                 |
| Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ | 1        | га                 |          |          | 4,4                      |
|  | 2        | мян.м <sup>3</sup> | -        |          | -                        |
| Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай                               | 3        | га                 | 8,5      | 0,12     | 7                        |
|  | 4        | мян.м <sup>3</sup> | -        | 6283     | 10 мян ширхэг мод тарих. |
| Нөхөн сэргээлтийн нийт хийсэн талбай   | 5        | га                 | 14,9     | 5,02     | 30                       |
|  | 6        | мян.м <sup>3</sup> | -        | 23,677   | 51,0 ширхэг мод тарив.   |
| Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай   | 7        | га                 | -        | 0,12     | -                        |
|  | 8        | мян.м <sup>3</sup> | -        | 13104    | -                        |
